



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 09 өдөр

Дугаар Б/04

Батширээт сум

**В.Чулуунд сахилгын шийтгэл  
ногдуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалт, 48 дүгээр зүйлийн 48.3 дахь хэсэг, Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын 1.4, 1.5.1 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн 7.1.8, 7.1.10 дахь заалтуудыг зөрчсөн Барх багийн Засаг дарга В.Чулуунд өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.
2. Цаашид алдаа дутагдал гаргалгүй үр бүтээлтэй ажиллахыг В.Чулуунд үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Бүдханд)-д даалгасугай.
4. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо тус шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор Төрийн албаны төв байгууллагад, эсхүл шүүхэд гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ

